



"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК

**"ГЭРЭЛТҮҮЛЭГЧ,ДУХНЫ ГЭРЭЛ ГАР ЧИЙДЭН"
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт: "Гэрэлтүүлэгч,духны гэрэл,гар чийдэн"

Тендерын дугаар: ХА-055/2019

Улаанбаатар хот 2019

ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019 оны 04 дугаар сарын 11-ний өдөр

Тендерийн нэр: “Гэрэлтүүлэгч,духны гэрэл,агр чийдэн“ нийлүүлэх
Тендерийн дугаар: **ХА-055/2019**

“УБЦТС” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос **“Гэрэлтүүлэгч,духны гэрэл,гар чийдэн”** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **20,000 /хорин мянган/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 10 цаг 30 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо,Чингисийн өргөн чөлөө 45.
УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж үйлчилгээний алба
Утас: 342420 +157, Факс: 976-341852
Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Захиалагч нь: "УБЦТС" ТӨХК</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Тендерийн нэр дугаар: Гэрэлтүүлэгч,духны гэрэл,агр чийдэн ХА-055 /2019</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн нэг жилийн /2018 /оны аудитлагдсан санхүүгийн тайлан ирүүлэх 2. Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгийн 80%-иас багагүй байх. 3. Сүүлийн нэг жил /2018 онд Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар ирүүлэх/ <p style="text-align: center;">Нэмэлт шаардлага</p> <ol style="list-style-type: none"> 4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга 5. Улсын бүртгэлийн гэрчилгээ 6. Үнийн саналыг маягтын дагуу баталгаажуулж ирүүлэх 7. Бараа нийлүүлэх хугацаа / хуваарь / 8. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт 9. ШШГЕГ-ын тодорхойлолт ирүүлнэ. 10. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь, тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна.Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын"-ын дагуу “татвар төлөлт,Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг шалгана”. 11. Нийлүүлэх барааны зураг болон, дэлгэрэнгүй тайлбарын хамт ирүүлэх 12. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. 13. Олон улсын чанарын стандартын шаардлага хангасан эсэхийг гэрчилэх,сэртификат орчуулж хавсарган ирүүлнэ. 14. Гэрээний үнэ, хугацаанд барааг нийлүүлэн хүлээлгэн өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ. 15. Захиалагч гэрээ байгуулах үед нэг бүрийн үнэ болон нийлүүлэх барааны техникийн нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТӨӨЗ 40.1-д заасан хувиар өөрчлөх эрхтэй бөгөөд энэхүү өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай албан мэдэгдэл ирүүлнэ.

	16. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ.
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр, 2 давхарт 206 тоот. Огноо: 2019 оны 04-р сарын 18 -ны өдөр Цаг: 10 цаг 00 минут Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.
ТӨӨЗ 2.2	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр, 2 давхарт 206 тоот, Огноо: 2019 оны 04 -р сарын 18-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй
ТӨӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Чанарын баталгаат хугацаа 6 сар байна.
ТӨӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцно. (Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол албан хүсэлт ирүүлэх ба ТБОНӨХБАҮХАТХуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 103 дугаар тогтоол /Сангийн сайдын 2007 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 81 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал"-ын дагуу тооцно/)
ТӨӨЗ 40.1	<ol style="list-style-type: none"> Захиалагч нийлүүлэх барааны тоо хэмжээг ихэсгэж болох хувь: Нийт барааны 20 хүртэлх хувь, Захиалагч нийлүүлэх барааны тоо хэмжээг багасгаж болох хувь: Нийт барааны 20 хүртэлх хувь, Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. <p>Жич: Нийлүүлэгчийн санал болгосон үнээр тухайн барааны тоо хэмжээг 20 хүртэлх хувиар бууруулж гэрээг байгуулна. Захиалагч агуулахын үлдэгдэл, нөөцийг хасч гэрээ байгуулах үед тоо хэмжээг тодорхойлно. Үүнд /духны гэрэл, ТББ-т заасан гэрэлтүүлгийн бараа материалуудыг тооцно.</p>

Гурав.

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ


1	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	Аваарын гарцын чиглэлийн гэрэлтүүлэг	ш	297	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
2	Аваарын гэрэл	ш	283	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
3	Духны гэрэл	ш	407	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
4	Дүүжин гэрэлтүүлэгч, НСП21-200-003-У3, 60Вт	ш	8	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
5	Зөөврийн гар чийдэн	ш	199	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
6	Зөөврийн гэрэл (NFC-140 маркийн 150Вт)	ш	2	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
7	Зөөврийн гэрэл (Чадал: 55Вт, Үргэлжилсэн гэрэлтүүлгийн цаг: 10ц Гэрэл:55SMD led Бранд: Yogeltackle T55)	ш	7	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
8	Зөөврийн гэрэлтүүлгийн чийдэн MO40-25	ш	1	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
9	Таазнаас зүүх гэрэлтүүлэгч, 4А НСП21-100-001У3	ш	12	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
10	Түмбэ /цацруулагчтай, замын босоо тэмдэглэгээ хаалт/	ш	51	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
11	Хамгаалагдсан дүүжин гэрэлтүүлэгч, дотор НСП21-200-003-У3, 60Вт	ш	4	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
12	Хамгаалагдсан ханын гэрэлтүүлэгч, дотор НБО-06Х100/p20-01У4, 60 Вт	ш	12	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
13	Хананаас зүүх гэрэлтүүлэгч, 4А НПБ	ш	8				



Техникийн тодорхойлолт

Аваарийн гэрэл, гарцын гэрэлд тавигдах техникийн шаардлага

Улаанбаатар хот

2019.04.04

Д/Д	Материалын нэр	Техникийн үзүүлэлт	Зориулалт	Тайлбар
1	<p>Онцгой байдлын /аваарийн/ гэрэл</p> 	<p>1. ISO 30061: 2007 стандарт /онцгой байдлын гэрэлтүүлгийн шаардлага/-ыг хангасан, аюулгүй байдлын гэрэлтүүлгийн ангилалд хамаарагдана. Аваарийн гэрэл нь их бие, гэрэл гэсэн үндсэн хийцтэй. Хэвийн ажиллагааны үед цахилгаан хангамжаас батарейг цэнэглэх, аваарын /цахилгаан хангамж тасарсан/ үед батарейны тэжээлээс гэрлээ асаах гэсэн үйл ажиллагааны 2 горимтой /гар болон автомат удирдлагын тавилтай/, зөөврийн гэрэлтүүлгэнд ашиглах боломжтой .</p> <p>2. Их бие нь батарейг агуулсан хайрцагтай, пластмасс материалтай, тавцанд тавих, хананд өлгөх, таазанд дүүжилж болох загвартай, цэнэглэгддэг батарейтай, батарейны багтаамж 1000МАН-аас дээш, Li-Ion төрлийн зайтай /гэрлийн лампны сонголтоос шалтгаалан бага тавил дээр 4 цагаас багагүй хугацаанд ажиллах нөөцтэй/, зайг хэт цэнэглэх буюу гүнзгийрүүлэхээс хамгаалах системтэй, батарей нь 10-аас дээш жил ажиллах чадамжтай. Их бие дээр техникийн өгөгдөл, загварын сериалын бичлэгтэй.</p> <p>3. Гэрэл нь лампыг хамгаалсан гэртэй, туузан буюу прожектор загварын гэрэлтэй, тод лед болон флюоресцент /30w-аас дээш/ ламптай байна.</p> <p>Туузан загвартай бол 1, прожектор загвартай бол 2-оос багагүй гэрэлтэй байна, гэрэл нь 60м2-аас багагүй талбайг гэрэлтүүлэх, гэрлийн тусгал 25м-ээс дотогш зайд сарнихгүй. Прожектор гэрэлтэй бол сууриараа бүтэн эргэх болон дээш доош өнцгийн тохируулга хийх боломжтой, туузан гэрэлтэй бол нүүрэн талын талбайд тусгалаас хамаарахгүйгээр гэрэлтүүлэх боломжтой загвартай.</p> <p>4. Температурын горим: -10°C-: +25°C.</p> <p>5. Жин 1.8 кг-аас ихгүй.</p>	<p>Цахилгаан хангамж тасрахад ерөнхий гэрэлтүүлэг хийх зөөврийн гэрэл</p>	<p>Аваарийн гэрлийн техникийн өгөгдөл, их бие дээрх бичлэг бичилт, дагалдах бичиг баримт буюу техникийн паспорт нь хоорондоо тохирсон байна. Ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааврыг монгол хэл дээр дагалдуулж өгөх. /Хэвийн ажиллагааны баталгааны хугацаа 1 жилээс дээш/</p>

<p>2</p>	<p>Гарцын /аваарийн/ гэрэлтүүлэг</p>  	<p>1. ISO 30061: 2007 стандарт /онцгой байдлын гэрэлтүүлгийн шаардлага/-ыг хангасан, аюулгүй байдлын гэрэлтүүлгийн ангилалд хамаарагдана. Гарцын гэрэлтүүлэг нь их биен дотор байрласан гэрэлтэй, хавтгай жаазан загвартай, хана, таазанд бэхлэх зориулалттай. Хэвийн ажиллагааны үед цахилгаан хангамжтай зэрэгцээ ажиллан гэрлээ асаалттай байлган батарейг цэнэглэх, аваарын /цахилгаан хангамж тасарсан/ үед батарейны тэжээлээс гэрлээ асаах гэсэн үйл ажиллагааны 2 горимтой /автомат удирдлагатай/, суурин гэрэлтүүлэг. Их бие нь батарейг агуулсан, гэрэл нэвтрэх пластмасс хайрцагтай, бичиглэл болон зураг нь гэрэл нэвтрэх тунгалаг цоолбор маягийн загвартай, цоолборын гадна хүрээ нь ногоон өнгийн гэрэл ойлгогчтой тунгалаг материалтай байна. Цоолбор нь EXIT гэсэн бичлэг болон гарцын хаалганы зураг дангаар, хосолмол байж болно. Гарцын гэрэлтүүлэг нь цэнэглэгддэг батарейтай, батарейны багтаамж 200МАН-аас багагүй, Li-Ion төрлийн зайтай /бага чадлын 2-10кд/м² тусгалтай тод лед болон флюоресцент ламптай, 12 цагаас дээш хугацаанд ажиллах нөөцтэй/, зайг хэт цэнэглэх буюу гүнзгийрүүлэхээс хамгаалах системтэй, батарей нь 10-аас дээш жил ажиллах чадамжтай. Их бие дээр техникийн өгөгдөл, загварын сериалын бичлэгтэй. Их биений /жаазны/ хэмжээ 1x2 /өндөр, урт/ харьцаатай, загвараас шалтгаалан хэмжээсийн /тохиромжтой хэмжээ 150x300мм/ сонголтыг хийнэ.</p> <p>2. Температурын горим: -10°C:-+25°C.</p> <p>3. Жин 0.8 кг-аас ихгүй.</p>	<p>Онцгой байдлын гарцыг чиглүүлэгч</p>	<p>Гарцын гэрэлтүүлгийн техникийн өгөгдөл, их бие дээрх бичлэг бичилт, дагалдах бичиг баримт буюу техникийн паспорт нь хоорондоо тохирсон байна. Ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааврыг монгол хэл дээр дагалдуулж өгөх. /Хэвийн ажиллагааны баталгааны хугацаа 1 жилээс дээш/</p>
----------	--	--	---	--

Ирүүлэх загвар болон нийлүүлэгдэх бараа материалд техникийн шаардлагын тодорхойлолтыг хангасныг нотлох үйлдвэрийн баримт /техникийн өгөгдөл буюу паспорт/, холбоо барих хаяг, майл хаяг хамт байна. Үйлдвэрийн туршилтын бичиг буюу сертификатыг хавсарган ирүүлнэ

Захиалагч талын тухайн бараа материал хариуцсан мэргэжилтэн, холбогдох хүмүүс нийлүүлэгдсэн бараа материалд үзлэг хийн хүлээж авахдаа баримт бичгийн бүрдэл, гэрчилгээ зэрэг холбогдох бичиг баримттай тулгаж шалгана. Үзлэгийн шаардлага хангахгүй бол /тендерт ирүүлсэн загвар, нийлүүлэгдсэн бараа материал зөрүүтэй байвал/ нийлүүлсэн бараа материалыг буцаах буюу шинжилгээнд хамруулж дүгнэлтийг үндэслэнэ.

Үзлэг, шалгалт, туршилтаар нийлүүлэгдсэн бараа материал нь техникийн тодорхойлолтыг хангаагүйгээс буцаах болон солиулахтай холбогдон гарах зардлыг захиалагч тал хариуцахгүй.

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Техникийн тодорхойлолт /дүйцэхүйц/
1	Аваарын гарцын чиглэлийн гэрэлтүүлэг	ш	297	Техникийн тодорхойлолт харах
2	Аваарын гэрэл	ш	283	Техникийн тодорхойлолт харах
3	Духны гэрэл	ш	407	Хол, ойрын, дохионы гэрэлтэй, цахилгаанаар болон батарейгаар цэнэглэгддэг Захиалагч агуулахын үлдэгдэл, нөөцийг хасч гэрээ байгуулах үед тоо хэмжээг тодорхойлно
4	Дүүжин гэрэлтүүлэгч,	ш	8	НСП21-200-003-У3, 60Вт
5	Зөөврийн гар чийдэн	ш	199	Хол, ойрын, дохионы гэрэлтэй, цахилгаанаар болон батарейгаар цэнэглэгддэг
6	Зөөврийн гэрэл	ш	2	(NFC-140 маркийн 150Вт)
7	Зөөврийн гэрэл	ш	7	(Чадал: 55Вт, Үргэлжилсэн гэрэлтүүлгийн цаг: 10ц Гэрэл:55SMD led Бранд: Yogeltackle T55)
8	Зөөврийн гэрэлтүүлгийн чийдэн MO40-25	ш	1	
9	Таазнаас зүүх гэрэлтүүлэгч, 4А НСП21-100-001У3	ш	12	Лед гэрэл буюу цахилгаан эрчим хүчинд хэмнэлттэй насжилт удаан байх. Суурьтай байх
10	Түмбэ /цацруулагчтай, замын босоо тэмдэглэгээ хаалт/	ш	51	Стандарт
11	Хамгаалагдсан дүүжин гэрэлтүүлэгч, дотор	ш	4	НСП21-200-003-У3, 60Вт
12	Хамгаалагдсан ханын гэрэлтүүлэгч, дотор	ш	12	НБО-06Х100/р20-01У4, 60 Вт
13	Хананаас зүүх гэрэлтүүлэгч,	ш	8	Лед гэрэл буюу цахилгаан эрчим хүчинд хэмнэлттэй насжилт удаан байх. Суурьтай байх 4А НПБ

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн
гүйцэтгэх захирал Д.Баярсайхан танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорх ойлолт	Бараан ы гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ажлын 90] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |

- 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Чанарын баталгаа, баталгаат засварын хугацаа 6 сар байна. Баталгаат засварын хугацааны барьцаа хөрөнгө гэрээний үнийн 5% байна.
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийг барааг хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн протокол болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
- 2.1. Алданги оногдуулах хувь: **0,1%**.
Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **10%-иас хэтрэхгүй**.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ___ дугаар сарын ___-наас _____ оны ___ дугаар сарын ___-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.